★ Та хэрэв өөрийн ундармал эх булгаа эрж олдог юм бол үүрд аваад баршгүй эх булагтай болно. Энэ чинь хязгааргүй буяны ач хариулал даа! Би ямар үг өгүүлбэрээр үүнийг дүрслэн хэлэхээ олохгүй байна. Би түүнийг зөвхөн шагшин магтах бөгөөд миний ингэж шагшин магтахыг чи итгээрэй гэж хүснэ. Миний хүчин чадал чиний оюун санааг бага ч гэсэн нөлөөлж, баяр баясгаланг сэрж олохуйц хэмжээнд хүртэл дээшлүүлэх үед чи үнэмшин итгэх болно доо. Сэтгэлийн авишиг авсны дараа чи миний үгний утга санааг жинхэнэ ойлгох болно. Хаан хурмастын надад олгож өгсөн, найдсан, өчүүхэн ч үнэ төлбөргүй, ямар ч нөхцөлгүйгээр хуваан эдлэх их хайрыг та нарт уламжлан өгөхөөс өөр арга надад алга.

—Sima Ching Hai—

★ Тэднийг олж харах, тэднийг бодож олох, тэдэнтэй хамт ном бичиг унших, тэдэнтэй хамт хоол идэх... зэргийн алинд ч хамаагүй, бид эргэн тойрон дахь хүмүүсийн биенээс үйл түйтгэрийг олж авах болно. Энэ бол бид бусад хүнийг адисалж, тэдний үйл үрийг хөнгөрүүлэхийн арга болох юм. Энэ нь мөн ч бясалгал хийж, гэрэл гэгээнийг тархааж, бүрхэг харанхуйг үлдэн хөөхийн арга болно. Үйл үрээ бидэнд юүлж өгсөн хүн буянтай даа! Бид тэднийг туслах дуртай юм.

—Shma Chung Hai—

★ Хүмүүс өдөр дуусан нэг олон хэрэггүй үг яриад зогсохгүй юм. Бид үүнийг харьцуулах, дүн гаргах, ялган таних хэрэгтэй, дараа нь бүгдэд нэр өгөх

хэрэгтэй. Гэтэл " туйлын эрхэм хаан хурмаст" бол Үнэхээр "ҮзҮҮргҮй эрхэм дээд" болохоор бид тҮҮнийг ярьж хэлэлцэхийн аргагҮй юм. Чи ярихын аргагҮй, бодох ч аргагҮй, дҮрслэх ч аргагҮй болоод, нэгмөсөн юу ч ҮгҮй хов хоосон болох юм. Ойлгов уу?

—Suma Ching Hai—

# БИДЭНТЭЙ ЯАЖ БОЛБОО АВАХ ТУХАЙ

Чинхай багшийн шавь буюу хамт бясалгагчид дэлхийн олон газарт маш олон салбар нийгэмлэг ба жижиг төвүүдийг байгуулжээ. Хэвлэл тархаах төв нь Тайваньд: "Suma Ching Hai – н дэлхийн нийгэмлэг—Тайваний Мяолишиху шуудангийн 9 – р захианы хайрцаг" болно.

Та нартай холбоо авах хүмүүс бол Арявалын номын цогцсыг бясалгаж, сэтгэлийн авишгийг нэгэнт авсан хамт бясалгагчид болох тул сэтгэлийн авишиг авахыг хүсэж байгаа буюу Чинхай багшийн номлолыг илүүхэн ойлгож мэдэхийг бодож байгаа бусад хүмүүст туслах чин сэтгэлийг барьжээ. Та нарын

асуултыг тэд дуртай хариулж өгөх болно. Тэд бас та нэрт тусалж чамд хамгаас илүү тохиромжтой дууны кассет, түрсний кассетыг сонгож өгөх болно. Үүнээс гадна бас Чинхай багшийн ном тавих, дияан бясалгах зэрэг ажиллагааг та бүхэнд цаг тухайд нь мэдэгдэх болно.